МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ

ГЭМТЭЛ СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ 2023 ОН

| № | Шалгуур үзүүлэлт | Хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|
| Нэг. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал | | | |
| 1.1 | Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн. | Байгууллагын (gemtel.mn) цахим хуудас болон мэдээллийн самбарт эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнг эмх цэгцтэй, ойлгомжтой байдлаар байршуулан, байнга шинэчилж, баяжуулалтыг хийж хөтлөн явуулдаг.<br>Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай, Шилэн дансны тухай хууль,<br>Эрхэм зорилго, үйл ажиллагааны зорилт, зорилго, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээллийг төвийн цахим хуудсанд байршуулан ил тод байдлыг хангаж ажилласан.<br>Эрхэм зорилго: Олон улсын стандартад нийцсэн гэмтэл согогийн цогц тусламж үйлчилгээг эрсдэлгүй, ээлтэй орчинд мэргэшсэн хамт олон тэгш, найрсаг үйлчилгээгээр хүртээмжтэй үзүүлнэ.<br>Төвийн хэмжээнд үйл ажиллагааны чиглэл бүрээр Олон улсын стандарт шаардлага хангасан байх зорилт тавьсан.<br>Лабораторын тасагт MNS ISO 15189:2015 шаардлага хангах ажил хийгдэж Үндэсний итгэмжлэлийн төвийн даргын 2023 оны 11 сарын 01-ны А/193 тоот тушаалын дагуу 2023 оны 11 сарын 21-22-ны хооронд анхан шатны үнэлгээ хийгдсэн. Үнэлгээний комиссоос 1 үл тохирол, 13 ажил сайжруулах зөвлөмж өгсөний хүрээнд ажлын хэсэг байгуулан,үл тохирол болон ажил сажруулах зөвлөмжийн дагуу засаж залруулах ажлыг хийж гүйцэтгэн тайланг хүргүүлэн хариу хүлээж байна. | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | | Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 Төвийн ерөнхий захирлын 2022 оны 5 дугаар сарын 11-ны өдрийн тушаалаар батлуулан. Календарчилсан төлөвлөгөөний дагуух ажлын үйл явцын тайлан 2023 оны 11 сарын 16 дотоод аудит явж 12 сарын 13-15-ны хоорон MonCertf ХХК-р гадаад аудит хийлгэн тус төлөвлөгөөт ажил амжилттай дуусах шатандаа орон ажиллаж байна. | |
| 1.2 | Чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг. | Гэмтэл согог судлалын үндэсний төв нь гэмтэл согогийн чиглэлээр лавлагаа шатлалын эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэх чиглэлээр бусад эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэшлийн арга зүйгээр хангах чиг үүрэг бүхий төрөлжсөн мэргэшлийн төв эмнэлэг юм.<br>ЭМСайдын 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн А/322 тоот тушаалаар батлагдсан.<br>**Төв эмнэлэг:**<br>Монгол Улс, Улаанбаатар хот, 16094, Баянгол дүүрэг, 31 дүгээр хороо, Дилав хутагт Жамсранжавын гудамж Утас: 7018-0136<br>**Салбар эмнэлэг:**<br>Монгол Улс, Улаанбаатар хот, 14192, Сүхбаатар дүүрэг, 7 дугаар хороо<br>Ж.Батмөнхийн гудамж<br>Утас: 77770136 | 100% |




2021 оноос CallPro ХХК-тай хамтран 7018-0136 тоот лавлагаа мэдээллийн утсыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна.

Цаг авах заавар

1. ГССҮТ-ийн Лавлах
2. Компьютер томограф өндөр өртөгт оношлогоо шинжилгээтэй хамааралтай
3. Эрүүл мэндийн даатгал, битүүмж
4. Эмнэлгийн тусламж үйлчилгээ чанар аюулгүй байдлын алба
5. Хэвлэл мэдээллийн ажилтан
6. Хүний нөөцийн алба
7. Салбар эмнэлгийн лавлах дараах байдлаар нээлттэй түргэн шуурхай холбогдон ажиллаж байна.

Байгууллагын албан хэргэцээнд ncto@gemtel.mn Цахим шуудангийн хаяг ашиглан ажиллаж байна.

| | | | |
|---|---|---|---|
| | | Эмнэлгийн үйл ажиллагааг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, ард иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, зөвлөмж зөвөлгөө хүргэх чиглэлийн хүрээнд facebook page хуудсанд өдөр бүр шинэ мэдээ мэдээллийг байршуулан ажиллаж байна. https://www.facebook.com/gemtelsogog<br>Тус төв нь 2023 онд өөрийн цахим хуудсыг бие даан хөгжүүлж одоогоор 100% гүйцэтгэлтэй ажиллаж байна. Цахим хуудсыг шинэчилсэнээр мэдээ мэдээллийг ард иргэдэд түргэн шуурхай хүргэх, хийгдэж байгаа эмчилгээ, мэс заслын танилцуулга, боловсон хүчний дэлгэрэнгүй танилцуулга, ил тод байдлын үзүүлэлтүүдийг багтаасан цахим хуудсыг шинээр баяжуулан ажиллаа. | |
| 1.3 | Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж | 2022 оны санхүүгийн аудитын шалгалтаар зөрчилгүй санал дүгнэлт авсан ба тухайн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:<br>1. 5 зөвлөмж өгсний 4 зөвлөмжийг 100%, 1 зөвлөмжийг 95% биелүүлсэн.<br>2. ЗГ-ын 114 дүгээр тогтоолын 3.3, 3.3.1-г мөрдөн ажиллаж зөрчлийг давтан гаргахгүй хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>Аудитын зөвлөмжийн хэрэгжилтийн тайланг хуулийн хугацаанд хүргүүлсэн. | 100% |
| 1.4 | Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан. | 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Үүний хүрээнд дараах байдлаар хуулийг хэрэгжүүлж ажилласан байна.<br>Ажилтан алба хаагчдын хөдөлмөрийн гэрээг шинэ хууль тогтоомжид нийцүүлэн шинэчилэн байгуулсан;<br>Хөдөлмөрийн хууль, тогтоомжийн хүрээнд хөдөлмөрийн дотоод журам, ажлын байрны дарамт, хүчирхийллээс сэргийлэх, гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэх журам зэргийг боловсруулан мөрдүүлж ажилласан; | 100% |
| 1.5 | Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан | Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа- 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, 2020 оны 23 дугаар | |

| | | | |
|---|---|---|---|
| | | тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” болон 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-нд тусгагдсан Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний стратегийн зорилт, арга хэмжээнүүдийг ханган ажилласан. | 100% |
| 1.6 | Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт. | Монгол Улсын эрүүл мэндийн салбарын үйл ажиллаганд мөрдөгдөж байгаа нийт 114 хууль тогтоомжоос Гэмтэл согог судлалын үндэсний төвийн үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хууль 100, эрүүл мэндийн салбарт нийтлэг мөрддөг 14 хуулийг хэрэгжүүлэн ажиллаж байна.Үүнээс:<br>**Тухайн салбарын хуулийн**<br>- Гэмтэл согог судлалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах чиглэлээр - 29<br>- Эрүүл мэндийг дэмжих, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр - 15<br>- Биотехнологи инновацын чиглэлээр - 9<br>- Тархвар зүй, шуурхай удирдлагын чиглэлээр - 6<br>- Санхүү аж ахуйн чиглэлээр -16<br>- Хоол, шим тэжээл судлал, хүнсний аюулгүй байдлын чиглэлээр - 8<br>- Лаборатори, оношилгоо шинжилгээний чиглэлээр – 1<br>- Тархвар зүй, шуурхай удирдлагын чиглэлээр – 6<br>**Нийтлэг мөрддөг хууль**<br>- Биеийн тамир, спортын тухай хууль<br>- Дархлаажуулалтын тухай хууль<br>- Донорын тухай хууль<br>- Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль<br>- Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль<br>- Хүний дархлал хомсдолын вирусийн халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай<br>- Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль<br>- Эрүүл ахуйн тухай хууль<br>- Эрүүл мэндийн тухай хууль | 100% |
| 1.7 | Албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр, | Гэмтэл согог судлалын үндэсний төвийн Ерөнхий захирлын 2023 оны 01 дугаар сарын 02 -ний өдрийн А/01 тоот тушаалаар Мэдээлэл технологийн албаны дарга Эрдэнэбаярын Батдоржыг Ил тод байдлын ажилтнаар ажиллуулж байна. | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг | Эрдэнэбаярын Батдоржыг<br>Холбоо барих дугаар: 88020213, 70180136<br>Цахим шуудангийн хаяг: ncto@gemtel.mn | |
| 1.8 | Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ | **Иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын 2023 оны тайлан**<br>/Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлын алба/<br>/2023 оны 01 сарын 01 – 11 сарын 01 хүртэлх/<br>2023 оны I- XI сард Гэмтэл согог судлалын үндэсний төвд иргэд, үйлчлүүлэгчдээс ирүүлдэг гомдол, санал, хүсэлтийг хүлээн авах нөхцлийг олшруулах, шийдвэрлэх асуудлыг ил тод болгохоор зорин ажиллаа.<br>Эрүүл мэндийн сайдын 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/50 дугаар тушаалын "Иргэд, үйлчлүүлэгчдээс ирүүлсэн гомдлыг шийдвэрлэх журам"-ын хавсралтын дагуу тайланг боловсруулсан болно.<br>2023 01 - 11 дүгээр сарын байдлаар Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албанд биечлэн, бичгээр, цахим, 11-11 төвөөр нийт **176** өргөдөл, гомдол, санал, хүсэлт хүлээн авч 100% шийдвэрлэн ажилласан.<br>**Өргөдөл, гомдол, санал, хүсэлт:**<br>• Бичгээр – 91<br>• Цахимаар – 4<br>• Утсаар – 4<br>• 11-11 төвөөр – 63<br>• Бусад-14<br>2023 оны I-III дугаар улиралд ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал | 100% |

| Д/д | Байгууллагын нэр | Нийт ирсэн Өргөдөл, гомдол | Шийдвэрлэлт | | | Хугацаа болоогүй | Шийдвэрлэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Шийдвэрлэж хариу өгсөн | Бусад байгууллагад шилжүүлсэн | Хугацаа хэтрүүлсэн | | |
| 1 | ГССҮТ | 176 | 174 | - | - | 2 | 98.86% |

Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт /төрөл/

| Д/д | Байгууллагын нэр | Нийт | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Бичгээр | 11-11 төвөөр | Цахимаар | Утсаар | Биечлэн | Бусад |
| 1 | ГССҮТ | 176 | 91 | 63 | 4 | 4 | 0 | 14 |

**График 1: Өргөдөл гомдлын төрөл – сараар нь**




Өргөдөл, гомдлын агуулга

| Д/д | Төрөл | Өргөдөл гомдлын нийт тоо | Нийт өргөдөлд эзлэх хувь |
|---|---|---|---|
| 1 | Харилцаа хандлага, ёс зүйн зөрчил | **30** | 27 % |
| 2 | Эмчилгээ, үйлчилгээний тайлбар хангалтгүй хийснээс иргэн буруу ойлголттой гомдол гаргах | **17** | 15.3 % |
| 3 | Эмнэлгийн тусламж, үйлчилгээний зохион байгуулалттай холбоотой | **13** | 11.7 % |
| 4 | Битүүмжтэй холбоотой | **9** | 8.1 % |
| 5 | Чанаргүй тусламж, үйлчилгээ. Оношилгооны алдаа | **9** | 8.1 % |
| 6 | Амбулаторийн хүлээгдэлтэй холбоотой | **8** | 7.2 % |
| 7 | Авто зогсоолтой холбоотой | **6** | 5.4 % |
| 8 | MRI шинжилгээний эвдрэлтэй холбоотой | **6** | 5.4 % |
| 9 | Ковидын урсгалтай холбоотой | **4** | 3.6 % |
| 10 | Галзуу, татрангийн вакцинтай холбоотой | **4** | 3.6 % |
| 11 | Эмчилгээ, үйлчилгээний чанаргүй тусламж үйлчилгээтэй холбоотой ЭМД-н төлбөртэй санал нийлэхгүй | **3** | 2.7 % |

| | | | |
|---|---|---|---|
| 12 | Эм тарианы буцаан олголт мөнгөн дүнтэй санал нийлэхгүй гомдол гаргах | **1** | 0.9 % |
| 13 | Эмчилгээний төлбөрийн задаргаа авах, санал нийлэхгүй | **1** | 0.9 % |
| | **Нийт** | **111** | **100 %** |

**График 2. Өргөдөл гомдлын утгга**



Санал хүсэлтийн агуулга

| Хүсэлт, саналын агуулга | | Нийт |
|---|---|---|
| 1 | Эм тарианы буцаан олголт | 23 |
| 2 | Хадаасны төрөл тодорхойлох | 23 |
| 3 | Тодорхойлолт | 6 |
| 4 | Бусад | 5 |
| 5 | Өвчний түүхээс холбогдох бичиг баримт хуулбарлан авах | 3 |
| 6 | CD хуулбарлан авах | 1 |
| 7 | MRI шинжилгээний оочир зохицуулах хүсэлт | 1 |
| 8 | Япон даатгалын маягт бөглүүлэх | 1 |
| 9 | Ажилчдын автобус | 1 |
| 10 | КТГ эвдрэлтэй холбоотой санал | 1 |
| | **Нийт** | **65** |




Өргөдөл, гомдлын төрөл

| Д/д | Төрөл | Бодит тоо | Нийт өргөдөл, гомдолд эзлэх хувь |
|---|---|---|---|
| 1. | Гомдол | 111 | 63.0 % |
| 2. | Мэдэгдэл /Хүсэлт/ | 61 | 34.6 % |
| 3. | Санал | 4 | 2.2 % |
| | **Нийт** | **176** | **100%** |

Амаар гаргасан өргөдөл, гомдлын тэмдэглэл

| Д/д | Овог, нэр | Өргөдөл гомдлын агуулга | Шийдвэрлэсэн байдал | Шийдвэрлэсэн албан тушаалтны нэр, гарын үсэг |
|---|---|---|---|---|
| 1 | Уянга | Манай ах түлэнхий эмнэлэгт үзүүлсэн, хэвтэн эмчлүүлэхгүй удаа дараа буцаагаад байна | Түлэнхий салбар эмнэлэгийн эмчлэгч эмчтэй холбогдсон ампутац хийлгэх өвчтөн шарханд эрүүл, эмгэгийн зааг гарсны дараа хэвтэн эмчлүүлнэ гэдгийг өвчтөнд сайн тайлбарлаж хэлсэн гэнэ. 2 удаагийн үзлэгт ар гэрээс хамт хүн ирээгүй. Ар гэртэй нь холбогдож эмчилгээ, үйлчилгээний буруу ойлголтыг засаж тайлбарлав | ЭМТҮЧАБА-ны мэргэжилтэн Э.Золбоо |
| 2 | Т.Отгонг эрэл | Түлэнхийн шарх ГССҮТ-д үзэхгүй, 11-р хороолол дахь эмнэлэгрүү чиглүүлсэн. ГССҮТ-д тусламж, үйлчилгээ үзүүлэх ёстой биздээ | ХАЯТТ-н эмчид хэлж үзүүлэн, зөвлөгөө өгсөн | ЭМТҮЧАБА-ны мэргэжилтэн Э.Золбоо |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 3 | Д.Батсай хан | Амбулаторийн тасгийн хүлээгдэл их байна. Оочир ихтэй байна | Амбулаторийн тасагт зохицуулга хийж ажиллахыг тасгийн эрхлэгч болон ахлах сувилагч нарт анхааруулж ажиллав. | ЭМТҮЧАБА-ны менежер Б.Билгүүн |
| 4 | Ууганба яр овогтой Энгүүн /9915775 9/ | ГТГТ-н өрөөний тохижилт хангалтгүй, сувилагч Соёлоо харилцаа хандлага ёс зүйн асуудал. | Тасгийн эрхлэгчийн хэмжээнд танилцуулан, өөрөөний тохижилтийн засварын санхүүжилтийг шийдүүлэх зорилгоор саналыг холбогдох алба, удирдлагуудад танилцуулсан | ЭМТҮЧАБА-ны эрсдэлийн менежер Д.Нацагбадам |
| 5 | Мөнхжар гал Нэргүй | Бүртгэлийн №4 номерийн ажилтны харилцаа хандлага. Өнөөдрийн цаг байхгүй маргааш өөрийн биеэр ирж цагаа ав гэсэн. Олон дахин наашаа цаашаа явах хэцүү байна | Хариуцсан ахлах ажилтан Б.Оюунд мэдэгдэж үйлчлүүлэгчийг тухайн өдөртөө цаг ав гэж буцааж буй асуудалд хяналт тавин, анхааран ажиллах талаас мэдэгдэх. Тухайн иргэнийг ирсэн өдөрт нь тухайн өдрийн дарааллын дагуу цаг өгхийг бүртгэлийн ажилчдад мэдэгдэж, | ЭМТҮЧАБА-ны мэргэжилтэн Э.Золбоо |

<table>
<tr>
<td></td>
<td></td>
<td>
<table>
<tr><td></td><td></td><td></td><td>анхаарч ажиллах талаас чиглэл өгсөн</td><td></td></tr>
<tr><td>6</td><td>Ёндон Болд / 89973636 /</td><td>ГСНСБМЗТ Санжаасүрэн эмч 09/04 нд 6 давхарт ирж үзүүлэн хэвтээрээ гэсэн мөртлөө хагалгаанд орцон байна. Хагалгаанд ороод удах байсан бол өдөр, хоногоо зохицуулаад хойшлуулж болоогүй юм уу. Өөр эмнэлэгт үзүүлэх гээд цаг авцан эмчийн цагийн зохицуулаггүй байдлаас болж би ажлаа алдаад удмааргүй байна</td><td>Санжаасүрэн эмчтэй холбогдож амбулаторийн түвшинд үзүүлж хэвтэн эмчлүүлэх хувиарын дагуу эмчлүүлэх болсон.</td><td>ЭМТҮЧАБА-ны мэргэжилтэн Э.Золбоо</td></tr>
</table>
</td>
<td></td>
</tr>
<tr>
<td>1.9</td>
<td>Хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл</td>
<td>ГССҮТөвийн үйл ажиллагаа, тусламж үйлчилгээний мэдээг өдөр тутам бүхий л тасаг нэгжүүдээс хүлээн авч, нэгтгэн “gemtel.mn” байгууллагын вэб сайт, “Гэмтэл согог судлалын үндэсний төв” ФБ хуудас, Тасгийн эрхлэгч албадын дарга нарын телеграм групп, “ГССҮТөвийн эмч нар”, “Осол гэмтлийн мэдээлэл” ФБ группээр дамжуулан байгууллагын дотоод хэрэгцээнд болон олон нийтэд зориулан мэдээлж байна. Мөн өдөр тутам burtgel.mohs.mn цахим системээр дамжуулан ЭМЯ, бусад холбогдох</td>
<td>100%</td>
</tr>
</table>

| | | | |
|---|---|---|---|
| | | удирдах шатны байгууллагуудад мэдээлж байгаа ба цаг үеийн онцлох үйл явдлын талаарх дүн шинжилгээ бүхий мэдээллийг холбогдох байгууллагуудад болон ГССҮТөвийн НЭМАлба, хэвлэлийн ажилтантай хамтран олон нийтэд зориулсан байдлаар бэлтгэн хүргэдэг.<br>Осол гэмтлээс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай тархвар зүйн судалгааг 5 жилийн байдлаар хийж, сэтгүүл болгон хэвлүүлж, хамтран ажилладаг эрүүл мэндийн салбарын болон бусад салбарын байгууллага, албан тушаалтан, мэргэжилтнүүдийг нотолгоонд суурилсан мэдээллээр ханган ажиллаж байна.<br>2023 оны байдлаар 5 жилийн тархвар зүйн судалгаа /тайлан сэтгүүл/-1, бусад байгууллагуудын хүсэлтээр болон тасаг нэгжүүдийн хүсэлтээр дүн шинжилгээт мэдээлэл-205, тусламж үйлчилгээний мэдээллийг өдөр тутам нэгтгэж, хэрэглэгчид хүргэсэн байна.<br>Монгол улсад 2019-2023 онд бүртгэгдсэн осол гэмтлийн тархвар зүйн судалгааны тайлан сэтгүүлийг хуваарын дагуу 2024 хэвлэн гаргахаар төлөвлөн ажиллаж байна. | |
| 1.10 | Мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр | “ОСОЛ ГЭМТЛЭЭС СЭРГИЙЛЭХ” мэдээ мэдээлэл<br>“ҮЕР УСНЫ АЮУЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ” мэдээ мэдээлэл<br>“ХҮҮХЭД-АЮУЛГҮЙ ОРЧИН” осол гэмтлээс урьдчилан сэргийлэх мэдээ мэдээлэл<br>ГССҮТ-ийн салбар эмнэлгийн “НЭЭЛТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ”-ийн мэдээ мэдээлэл<br>“ГЭМТЭЛ СОГОГ СУДЛАЛЫН XXV ЭРДМИЙН ЧУУЛГАН”-ны мэдээлэл<br>“НЭГ ЗАМ-НЭГ СОЁЛ” аяны мэдээлэл<br>“ҮНДЭСНИЙ ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖИЙН БАГ”-ийг чадавхжуулах сургалт<br>“БИД СУВИЛАГЧ-БИДНИЙ ИРЭЭДҮЙ” аяны<br>“ЭРҮҮЛ МЭНДИЙН ТЕХНОЛОГИ-олон улсын экспо-2023”<br>“ИРГЭДЭД ЗОРИУЛСАН АНХНЫ ТУСЛАМЖ” үзүүлэх өртөөчилсөн сургалтын мэдээлэл<br>“ЭРҮҮЛ - ЭРСДЭЛГҮЙ ЦАГААН САР" аяны мэдээлэл<br>“ЭМЧ БИДНЭЭС- ИРГЭН ТАНААС” аяны мэдээлэл | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | | “ЭНЭ ЖИЛДЭЭ – ЭРҮҮЛ ЖИНДЭЭ” аяны<br>“ЭРҮҮЛ ЧИЙРЭГ ЭР ХҮН” аяны мэдээлэл<br>“ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН” үндэсний фестивалийн мэдээлэл | |
| Хэсгийн дундаж хувь: 100% | | | |
| Хоёр. Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал | | | |
| 2.1 | Ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл; | Хүний нөөцийн бүрдүүлэлт сонголтын үйл ажиллагаа ажлын байрны зар, мэдээллийг иргэдэд хүртээмжтэй хүргэх, ил тод байдлыг хангах зорилгоор дараах сайтуудад зар байршуулж байна.<br>- www.gemtel.mn<br>- www.zangia.mn<br>- www.facebook.com/Гэмтэл согог судлалын үндэсний төв<br>- www.chd.mohs.mn<br>- www.facebook/Гэмтэл согог судлалын үндэсний төвийн захиргаа хүний нөөцийн алба/групп<br>- Нийслэл, БГДүүргийн хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс<br>- Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв<br>15 ажлын байр зарлагдсаны дагуу 241 ажилтан томилсон. | 100% |
| 2.2 | Албан хаагч, ажилтны сонгон шалгаруулах журам | 2018 оны 11-р сарын 05-ны өдрийн А/398 тоот тушаалын 4-р хавсралтаар “Хүний нөөцийн бүрдүүлэлт, сонгон шалгаруулалтын журам”-ыг батласан. Мөн 2022 онд Ерөнхий захирлын А/12 тоот тушаалаар Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн баталж 4.5,4.6,4.7-д тус тус тусгасан болно. | 100% |
| 2.3 | Албан хаагч, ажилтны ёсзүйн дүрэм | Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/406 тоот тушаалын хэрэгжилтийг хангуулах зорилтын хүрээнд “Эмнэлгийн мэргэжилтний ёсзүйн дүрэм”-ийг “Гэмтэл согог судлалын | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | | үндэсний төв”,” Гэмтэл согог судлалын үндэсний төвийн захиргаа хүний нөөцийн алба” цахим хуудсаар мэдээллийг дамжуулсан. | |
| 2.4 | Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам | Ерөнхий захирлын 2018 оны 398 тоот тушаалын дагуу Хүний нөөцийн хөгжлийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмын дагуу Хөтөлбөрийн үр дүнг жил бүрийн 12 дугаар сард дүгнэж хяналт шинжилгээ, үнэлгээ хийгдэж хэвшсэн.<br>“Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр” хэрэгжсэнээр:<br>Хүний нөөцийн менежментийн ур чадвар бэхжинэ.<br>Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, хуваарилалтад ахиц өөрчлөлт гарч чадвартай боловсон хүчнээр хангагдана.<br>Төрийн албан хаагчийн мэдлэг чадвар сайжирна. Тэдний ажлын бүтээмж дээшилж, Хүний нөөцийн хуваарилалт сайжирч, боловсон хүчин мэргэшсэн, тогтвортой болно.<br>Төрийн албан хаагчид тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах нөхцөл бүрдэнэ. Түүнчлэн энэхүү хөтөлбөр хэрэгжсэнээр хүний нөөцийн судалгаа боловсронгуй болно. Уг хөтөлбөр мэдээллүүдийг цахим хаяганд байршуулсан.<br>Хүний нөөцийн менежментийн ур чадвар бэхжинэ.<br>Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, хуваарилалтад ахиц өөрчлөлт гарч чадвартай боловсон хүчнээр хангагдана.<br>Төрийн албан хаагчийн мэдлэг чадвар сайжирна. Тэдний ажлын бүтээмж дээшилж, Хүний нөөцийн хуваарилалт сайжирч, боловсон хүчин мэргэшсэн, тогтвортой болно.<br>Төрийн албан хаагчид тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах нөхцөл бүрдэнэ. Түүнчлэн энэхүү хөтөлбөр хэрэгжсэнээр хүний нөөцийн судалгаа боловсронгуй болно. Уг хөтөлбөр мэдээллүүдийг цахим хаяганд байршуулсан. | 100% |
| 2.5 | Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ | ГССҮТөвийн цахим хуудасны хууль эрх зүй цэсний “Захирлын тушаал” хэсэгт тогтмол тушаал шийдвэрүүдийг байршуулан ил тод, нээлттэй байдлыг ханган ажиллаж байна. | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| 2.6 | Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийнг үнэлэх журам | Цахим хуудсандаа ажлын гүйцэтгэлийн үнэлгээний загвар, аргачлалыг шинэчлэн боловсруулж, Эмнэлгийн ерөнхий захирлын 2020 оны 06 дугаар сарын 09-ны А/59 тоот тушаалаар батлан мөрдөж, засгийн газрын тогтоолын дагуу нэмэгдэл, мөнгөн урамшууллын болзлын дагуу дүгнэн улирал тутам үндсэн цалингийн 10-20 хувийн урамшуулал олгож байгаа талаар байршуулан ажилласан. | 100% |
| Хэсгийн дундаж хувь: 100% | | | |
| Гурав. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх | | | |
| 3.1 | Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл | 2022 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн тайлан, мэдээг 2022.01.05-ний өдөр, 2023 оны батлагдсан төсөв 63,377,036,000 төгрөг бөгөөд зардлын бүлэг тус бүрээр 2022.01.04-ны өдөр,<br>2024 оны жилийн төсвийн төслийг 09-р сарын 15-ны өдөр тус тус шилэн дансны болон байгууллагын вэб сайт, мэдээллийн самбаруудад мэдээлсэн. | 100% |
| 3.2 | Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан | Төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг сар бүрийн 5-ны дотор, 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2023 оны 04 сарын 05-ны өдөр, 2023 оны хагас жилийн тайланг 2023 оны 08 сарын 01-ны өдөр шилэн дансны нэгдсэн вэб сайт, байгууллагын вэб сайт, мэдээллийн самбаруудад мэдээлсэн. | 100% |
| 3.3 | Санхүүгийн тайлан хийсэн аудитын дүгнэлт | 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг 2023 оны 04 сарын 05-ны өдөр шилэн дансны нэгдсэн вэб сайт, байгууллагын вэб сайт, мэдээллийн самбаруудад мэдээлсэн. | 100% |
| 3.4 | Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ | ЭМД-н сангаас санхүүжих оношийн хамааралтай бүлгийн болон хувь хүний хамтын төлбөрийн хэмжээг шинэчлэн баталсан ЭМДҮЗ-ийн 2022 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн 01 дугаар тоот тогтоолын дагуу ерөнхий захирлын 2022 оны 03 сарын 01 ний № А/32 тоот тушаалыг 2022 оны 03 сарын 02-ны өдөр, ЭМДҮЗ-ийн 2023 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 08 дугаар тоот тогтоолын дагуу ерөнхий захирлын 2023 оны 08 | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | | сарын 24 ний № А/110 тоот тушаалыг 2022 оны 12 сарын 08-ны өдөр шилэн дансны нэгдсэн вэб сайт, байгууллагын вэб сайт, мэдээллийн самбаруудад мэдээлсэн.<br>“Эмнэлгийн төлбөртэй тусламж үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээ үзүүлэх журам, жагсаалт батлах тухай“ 2023 оны 12 сарын 06-ний Ерөнхий захиралын А/147 тоот тушаалыг 12 сарын 12-ны өдөр шилэн дансны нэгдсэн вэб сайт, байгууллагын вэб сайт, мэдээллийн самбаруудад мэдээлсэн | |
| 3.5 | Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар | Төсвийн хэмнэлт, хэтрэлтийн талаар **853** тайлбар мэдээллийг улирал бүрийн 5-ны дотор шилэн дансны вэб сайтад байршуулсан. | 100% |
| 3.6 | Таван сая, түүнээс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг | Эм бэлдмэл, өндөр өртөгт мэс засалд хэрэглэгдэх хэрэгсэл, хоол хүнс, бусад хангамжийн материалтай холбоотой худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний талаарх мэдээллийг хавсралт 8-ын дагуу бэлтгэж 531 ширхэг 19,613,112,201.08 төгрөгийг шилэн дансны нэгдсэн вэб сайт, байгууллагын вэб сайт, мэдээллийн самбаруудад гүйлгээ гарсан тухай бүр тус тус хуулийн хугацаанд мэдээлсэн. | 100% |
| 3.7 | Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр. Гүйлгээний агуулга, аүлээн авагчийн нэрийн хамт | Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого- 201 ширхэг 36,450,042,322 төгрөгийн гүйлгээ, зарлагын 863 ширхэг 28,534,963,831,38 төгрөгийн гүйлгээг хүлээн авагчийн нэр, гүйлгээний утга, мөнгөн дүнг шилэн дансны нэгдсэн вэб сайт, байгууллагын вэб сайт, мэдээллийн самбаруудад тухай бүр нь мэдээлсэн | 100% |
| 3.8 | Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр | Өр, авлага үүссэн тооцоо судалгааг тайлбарын хамт, тендер, тендер бусаар хийгдсэн гэрээ, мөнгө хөрөнгө зарцуулах тухай Ерөнхий захирлын тушаалыг PDF хэлбэрээр сар бүр шилэн дансны нэгдсэн вэб сайт, байгууллагын вэб сайт, мэдээллийн самбаруудад тус тус мэдээлсэн. | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| 3.9 | Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл |  | СБА 100% |
| 3.10 | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан | Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2023.01.10 өдөр, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгааны талаар мэдээллийг тухай бүр нь Хавсралт 8-ын дагуу шилэн дансны нэгдсэн вэб сайт, байгууллагын вэб сайт, tender.gov.mn сайт, мэдээллийн самбарууудад тус тус мэдээлсэн. | 100% |
| 3.11 | Худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт, шалгалтын тайлан, дүгнэлт | Худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт хийгдээгүй. | |

| | | | |
|---|---|---|---|
| 3.12 | Мэдээлэл хариуцагч болон захиалагч байгуулллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил аргазүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл | Хамааралгүй | - |
| 3.13 | Төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн | ДЭМБ-аас санхүүжүүлсэн<br>Үндэсний яаралтай тусламжийн баг бэлтгэх сургалтыг зохион байгуулах 44,553.00 мянган төгрөгийн төсөл хэрэгжүүлсэн.<br>Дэмжих сан<br>Монгол улсын хүн амын түлэгдэлтийн шалтгаан ба эмчилгээний үр дүнг судлах төслийн 17,934.8 мянган төгрөг. Үүнээс 70%-хийгээд байна. | 100% |
| 3.14 | Мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан | Судалгаа хийгдээгүй | - |
| 3.15 | Хууль тогтоомжид заасан бусад | Хамааралгүй | - |
| Хэсгийн дундаж хувь: 100% | | | |
| Дөрөв. Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээлэл | | | |
| 4.1 | Үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл | ЭМД-н сангаас санхүүжих оношийн хамааралтай бүлгийн болон хувь хүний хамтын төлбөрийн хэмжээг шинэчлэн баталсан ЭМДҮЗ-ийн 2022 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн 01 дугаар тоот тогтоолын дагуу ерөнхий захирлын 2022 оны 03 сарын 01 ний № А/32 тоот тушаалыг 2022 оны 03 сарын 02-ны өдөр, ЭМДҮЗ-ийн 2023 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 08 дугаар тоот тогтоолын дагуу ерөнхий захирлын 2023 оны 08 | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | | сарын 24 ний № А/110 тоот тушаалыг 2022 оны 12 сарын 08-ны өдөр шилэн дансны нэгдсэн вэб сайт, байгууллагын вэб сайт, мэдээллийн самбаруудад мэдээлсэн.<br>“Эмнэлгийн төлбөртэй тусламж үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээ үзүүлэх журам, жагсаалт батлах тухай“ 2023 оны 12 сарын 06-ний Ерөнхий захиралын А/147 тоот тушаалыг 12 сарын 12-ны өдөр шилэн дансны нэгдсэн вэб сайт, байгууллагын вэб сайт, мэдээллийн самбаруудад мэдээлсэн. | |
| 4.2 | Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа | Гэмтэл согог судлалын үндэсний төвийн тусгай зөвшөөрлийн хугацаа 2023-12-25ниы өдөр дуусч байгаа тул ЭМС-ийн 2023-11-03 ны өдрийн А/383 тоот тушаалын дөрөвдүгээр хавсралтын дагуу бичиг баримтуудыг бүрдүүлэн Эрүүл мэндийн яаманд цаасан болон цахим хэлбэрээр хүргүүлсэн болно.<br><br>ГЭМТЭЛ СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ<br>16081 Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 7-р хороо Дилав хутагт Жамсрангийн гудамж Утас/Факс: (976) 70187796 http://gemtel.mn<br>2023.12.07 № 01/1355<br>ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗАРТ<br>Хүсэлт хүргүүлэх тухай<br>Гэмтэл согог судлалын үндэсний төв нь улсын хэмжээнд гэмтэл, согог судлалын мэргэшсэн тусламж, үйлчилгээг үзүүлэх, сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэх, бусад эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжил, арга зүйгээр хангах чиг үүрэгтэй билээ.<br>Тус төвийн "Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ"-ний хугацаа 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдөр дуусаж байгаа ба гэмтэл согогийн чиглэлээр төрөлжсөн мэргэжлийн болон лавлагаа тусламж үйлчилгээ үзүүлэн ажиллах зөвшөөрлийг сунгах хүсэлт хүргүүлж байгааг хүлээн авч шийдвэрлэж өгнө үү.<br>Жич: Хавсралтаар холбогдох баримт бичгийг хүргүүлэв.<br>ЗАХИРАЛ Э.ГАЛБАДРАХ<br><br>Эрүүл мэндийн сайдын 2023 оны 11 сарын 03 ... өдрийн А/383 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт<br>ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН СУНГАЛТ ХИЙХЭД БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН БҮРДЛИЙН ХЯНАЛТЫН ХУУДАС<br>Хүсэлт гаргагч байгууллагын нэр: ГССҮТ<br>Тусгай зөвшөөрлийн төрөл, чиглэл:<br>Материал хүлээн авсан огноо:<br>Тусгай зөвшөөрлийн мэдээлэл (гэрчилгээний дугаар, дуусах хугацаа)<br>Материал ирүүлсэн эх сурвалж:<br>Эх сурвалж / Тэмдэглэгээ (V)<br>Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийн цахим системээр<br>Албан хэрэг хөтлөлтийн "Эбла" цахим систем — Цаасан ✓, Цахим ✓<br>Баримтын бүрдэл:<br>№ / Баримт бичгийн жагсаалт / Хүлээн авсан (V): Тийм, Үгүй / Дахин бүрдүүлсэн хугацаа<br>1 Зөвшөөрөл хүссэн өргөдөл, албан бичиг ✓<br>2 Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ ✓<br>3 Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ (эх хувиар) ✓<br>4 Эрхлэх үйл ажиллагааны төрөлд хамаарах техникийн зохицуулалт, стандартын дагуу мэргэжлийн ажилтнуудын дэлгэрэнгүй мэдээлэл (Эрүүл мэндийн сайдын тушаалд заасны дагуу) ✓<br>5 Мэргэжлийн ажилтан тус бүрийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт, сүүлийн 3 жилээр (НД-7, НД-8 дугаар маягтаар) ✓<br>6 Аж ахуйн нэгж, байгууллагын татвар төлөлтийн тодорхойлолт ✓<br>7 Үндэсний статистикийн хорооны даргын тушаалаар батлагдсан хүний нөөц болон үйл ажиллагааны тайлан (сүүлийн 3 жил)-г гаргасан талаарх Эрүүл мэндийн хөгжлийн төв, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дүгнэлт ✓<br>8 Эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмж, протез импортлох, ханган нийлүүлэх байгууллагын сүүлийн 3 жилийн импорт, экспортын мэдээлэл ✓<br>9 Тусгай зөвшөөрөл олгосон хугацаанд тухайн байгууллагын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн дүгнэлт ✓<br>10 Засгийн газрын тогтоолоор "Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын жагсаалт"-д багтсан эрүүл мэндийн байгууллагын мэдээллийн технологийн (программ хангамж, цахим систем, сервер...) кибер аюулгүй байдлыг хангасан талаарх Тагнуулын байгууллагаас гаргасан дүгнэлт, холбогдох байгууллагын зөвшөөрөл ✓<br>Тайлбар:<br>Хүлээн авсан мэргэжилтэн: Гарын үсэг / Нэр<br>2023.12.11- ний 11 цагт хүлээн авав. БХА Т.Нарантуяа<br>263695<br>17 | 100% |
| Хэсгийн дундаж хувь: 100% | | | |
| Тав. Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал | | | |
| 5.1 | Олон нийтээр хэлэлцүүлж санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, | Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгатай холбоотойгоор Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн эмч, эмнэлгийн ажилтнуудад танилцуулан | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага иргэнээс өгсөн санал | санал хүсэлтийг авч, тусган Ерөнхий захирлын 2022 оны А/12 тоот тушаалаар батлан мөрдлөгө болгон ажиллаж байна.<br>Цахим хуудас ил тод байдал, үйл ажиллагаа цэсэнд нээлттэй санал асуулга авах нөхцөлийг бүрдүүлэн ажилласан. | |
| 5.2 | Эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт | | - |
| 5.3 | Хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн явцын талаарх мэдээлэл | Нийслэлийн Засаг даргын 202 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/1318 тоот шийдвэртэй, 1680610018 нэгж талбарын дугаартай “Эмнэлэг” зориулалтаар эзэмшүүлсэн газарт өргөтгөл бариулах 577.44м2 барилгын дугаар: МЗХ2022/08-004 2022 оны 04 сарын 04 өдөр Архитектур төлөвлөлтийн даалгавар гаргуулсан. Нийслэлийн Ерөнхий архитектор Н.Нацагдоржийн 2022 оны 10 сарын 27-ны өдөр баталсан Архитектур төлөвлөлтийн даалгаварын дагуу “Нью синдкат” ХХК-аар “Гэмтэл согог судлалын үндэсний төв эмнэлгийн өргөтгөлийн барилга”-ын зураг гаргуулав. | 100% |
| 5.4 | Мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл | Нийслэлийн Засаг даргын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/1318 тоот шийдвэртэй, 1680610018 нэгж талбарын дугаартай, Баянгол дүүргийн 07 дугаар хорооны нутаг дэвсгэрт, “Эмнэлэг” зориулалтаар эзэмшүүлсэн 32398.0 м2 газартай болно.<br>Салбар эмнэлэг УБ хот Сүхбаатар дүүрэг 7-р хороо 366 м.кв эмнэлгийн зориулалт<br>Гэмтэл согог судлалын үндэсний төвийн цахим хуудас Gemtel.mn-д байршуулсан болно.<br>https://egazar.gov.mn/map?parcel_no=1680610018 | 100% |
| 5.5 | Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь | Хамааралгүй | - |

| | | | |
|---|---|---|---|
| | хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг | | |
| 5.6 | Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрхзүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл | Хамааралгүй | |
| 5.7 | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, | Гэмтэл согог судлалын үндэсний төв нь 2023 онд төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө болох эмнэлгийн төв байранд 136,5 м.кв талбай бүхий 16 байр талбайг 14 иргэн, хуулийн этгээдтэй төрийн өөрийн өмчийг түрээслүүлэх түрээсийн гэрээгээр ашиглуулж төрийн өмчийн үр ашгийг дээшлүүлж байна. Энэ оны байдлаар 124,8 сая төгрөг төвлөрүүлсэн. | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл | Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ зардлаа нөхөж, цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй, техник технологийн болон хэрэглээний хоцрогдолд орсон 94 нэр төрлийн 338 ширхэг 2,3 тэрбум төгрөгийн хөрөнгийг актлуулах саналыг дээд шатны байгууллагад хүргүүлсэн. | |
| 5.8 | Мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл | Хамааралгүй | |
| 5.9 | Барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт | Захиалагч тал буюу ЭМЯ, гүйцэтгэгч тал буюу “Цаст констракшн” ХХК-ны хооронд байгуулсан “Ажил гүйцэтгэх гэрээ”-ний дагуу ГССҮТөвийн харьяа Түлэнхийн төвийн А,Б блокийн барилгын ажлыг дуусгаж 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдөр Улсын комисс ажлуулсан бөгөөд гишүүдийн саналаар үүрэг даалгаварын биелэлтээр барилгыг ашиглалтанд хүлээн авахаар болсон. БНбД-ийн дагуу гүйцэтгэгч нь ашиглагч ГССҮТөвд<br>1. Барилгын иж бүрэн зураг 18 боть<br>2. Барилга байгууламжийн хувийн хэрэг 1 дэвтэр<br>Үндсэн хөрөнгийн жагсаалт 47 хуудас зэргийг хүлээлгэн өгсөн. | 100% |
| 5.10 | Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтаой холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагаас тусгай | Хамааралгүй | |

| | | | |
|---|---|---|---|
| | зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ | | |
| 5.11 | Нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй мэдээллийн сан дахь нээлттэй өгөгдөл | Гэмтэл согог судлалын үндэсний төвийн www.gemtel.mn цахим хаягнаас<br>Тусламж үйлчилгээ цэснээс цагийн хуваарь, хүлээн авах яаралтай тусламж, үзлэгийн цаг авах, хэвтэн эмчлүүлэх, төлбөрт тусламж үйлчилгээ, төлбөр тооцоо даатгал, зөвлөгөө гарын авлага<br>Бидний тухай цэснээс захирлын мэндчилгээ, түүхэн замнал, эрхэм зорилго, бүтэц зохион байгуулалт<br>Мэдээ мэдээлэл<br>Эмч мэргэжилтнүүд<br>Хууль эрх зүй цэснээс засгийн газрын тогтоол,ЭМСайдын тушаал, ерөнхий захирлын тушаал, журам, дүрэм, тендрийн урилга,<br>Ил тод байдал цэснээс хүний нөөцийн ил тод байдал, монгол улсын осол гэмтлийн өвчлөл нас баралт, гссүтөвийн үйл ажиллагаа статистик мэдээлэл, үйл ажиллагааны ил тод мэдээлэл,чанар дотоод хяналтын ил тод мэдээлэл нээлттэй авч болно.<br>Гэмтэл согог судлалын үндэсний төв нүүр хуудаснаас осол гэмтлээс сэргийлэх зөвлөгөө зөвлөмж, ажлын зар, талархал, өдөр тутмын тоон мэдээг нээлттэй авч болно. | 100% |
| 5.12 | Мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт | | - |

| | | | |
|---|---|---|---|
| 5.13 | Хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл | | |
| Хэсгийн дундаж хувь: 100% | | | |
| Хэрэгжилтийн дундаж хувь:100% | | | |

Тайлагнасан Мэдээлэл технологийн албаны дарга ................................ /Э.Батдорж/

Хянасан Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал ..................................... /Б.Батзориг/